

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2-4
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	2-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
03 дугаар сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг, Ж.Мөнхбат, Н.Учрал, Ж.Чинбүрэн.*

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

**Г.Мөнхцэцэг:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 64.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим 12 цаг 17 минут

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Мөнхцэцэг:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн тул эхлүүлье. Ирцийн мэдээг танилцуулъя. Ирвэл зохих 17 гишүүнээс Адъяасүрэн гишүүн чөлөөтэй. Анужин гишүүн ирсэн байна. Аубакир гишүүн ирсэн байна. Баатарбилэг гишүүн чөлөөтэй байна. Баярсайхан гишүүн ирсэн байна. Батшугар гишүүн ирсэн байна. Ганхуяг гишүүн ирээгүй байна. Дамдинням гишүүн ирсэн байна. Жаргалмаа гишүүн ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Ундррам гишүүн ирсэн байна. Чинзориг гишүүн ирсэн байна. Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Ирц бүрдсэн тул хуралдааныг эхэлье.

Өнөөдрийн хуралдаанаар 1 асуудал байгаа.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Тогтоолын төслийг батална. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдрийн хуралдаанаар 03 дугаар сард манай Байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг цаглаварыг батлахаар байгаа. Цаглаварыг та бүхэнд тараасан учраас танилцсан байх. Тогтоолын төсөлтэй

холбоотойгоор саналтай гишүүн байна уу. Асуулттай гишүүн байна уу. Ундррам гишүүнээр тасаллаа. Ундррам гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундррам:** Өнгөрсөн сар гаруй хугацаанд миний бие Сэлэнгэ аймгийн сумд, тосгодоороо явж ард иргэдтэйгээ уулзаад ирсэн. Энэ хооронд мэдээж боловсролын салбарын болон соёлын салбарын төлөөллүүд, мэргэжилтэн, ажилтнуудтай уулзсан. Тэгээд эдгээр хүмүүстэй холбоотой асуудлыг бид нар ер нь энэ Байнгын хорооны ажлын төлөвлөгөөнд оруулаад яривал яасан юм бэ гэсэн санал байна. Жишээлбэл ерөнхий боловсролын сургуулийн тогооч, нягтлан, нярав гэх мэтчилэн ийм албан тушаал хашидаг хүмүүсийн цалин огт нэмэгдээгүй, маш доогуур байна гэсэн энэ асуудлыг манай ерөнхий боловсролын сургуулийнхан тавьж байна. Энэ нь бас үзцэрлэг дээр яг адилхан байгаа юм. Тэгэхээр энэ хүмүүсийн цалин болон төсөвтэй холбоотой асуудлыг ажлын төлөвлөгөөндөө оруулаад ярих санал байна.

Хоёрдугаарт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах эрх хангагдаж байгаа эсэхтэй холбоотой ажлын хэсэг дээр Жаргалмаа гишүүн бид 2 нэлээн олон ажил хийсэн. Энэ ажлын тайланг танилцуулах шаардлагатай байна. Тэгэхээр энийг 3 сардаа багтаагаад Байнгын хорооны цаглаварт оруулаад хэлэлцмээр байна.

Гуравдугаарт, Номын сангийн асуудал байна. Энэ хөдөө орон нутаг, сумдад байгаа номын сангийн статус нэлээн ойлгомжгүй байна. Нэг талаараа соёлын салбарт хамаараад, нөгөө талаараа сургууль дээр байрлаж байгаа номын сан нь боловсролын салбар ч юм шиг, дунд нь хаягдаад байна гээд. Энэ номын сангийн орчин нөхцөл бол маш хүнд байна. Ном баяжуулалтын жилийн төсөв нь 80 мянган төгрөг байдаг гэж ярьж байна. Мөн ажилчдын цалин пүнлүү маш бага байна. Номын сангийн

тухай хуулийн хэрэгжилтийг бид нар соёлын салбартайгаа хамтраад Монгол Улсын Их Сургууль дээр нэг удаа хийсэн байгаа. Тэгээд номын сангийн тухай хуулийг бид нар илүүл сайжруулж ажиллах ёстой юм байна гэдэг дээр Соёлын яам бол санал нэгдсэн байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас энэ ажлын төлөвлөгөөндөө оруулж ярилцмаар байна гэсэн ийм саналууд байна.

**Г.Мөнхцэцэг:** Ундрам гишүүний саналыг сонслоо. Бид нар яг цаглавар дотроо ер нь манай Байнгын хорооны хэлэлцэх асуудлын гол юм бол Боловсролын багц хууль байгаа. 3 дугаар сард бид нар энэ хаврын чуулганаар Боловсролын багц хуулийг батална гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Тэгэхээр цаглавар маань үндсэндээ Боловсролын багц хууль руугаа чиглэсэн ийм асуудлуудыг хэлэлцэнэ гээд цаглаварт тусгасан. Гэхдээ бид нар 3 сарын 29-нд Байнгын хороо хуралдахаар төлөвлөөд цаглаварт тусгасан учраас яг энэ Байнгын хорооны 29-ны хуралдааны үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хуультай холбоотой тайланг сонсъё гэсэн ийм саналыг оруулъя. 29-ны хуралдаанд Жаргалмаа гишүүн, Ундрам гишүүн маань тайлангаа тавьж болно гэдгийг хэлье.

Номын сантай холбоотой ер нь цаашдаа Байнгын хороо маань хуралдаад явах учраас ер нь яг соёлын чиглэлээр Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль ору ирэхээр явж байгаа. Тийм учраас соёлын чиглэлээр ялангуяа номын сан, музейтэй холбоотой асуудлуудыг дараа дараагийн Байнгын хороо дээрээ тавиад энэ саналуудыг яриад хэлэлцээд явах бололцоо байгаа байх гэж бодож байна.

Сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдын цалингийн асуудал бол хөдөө орон нутаг гэхгүй хаа сайгүй энэ асуудал яригдаж байгаа. Манай гишүүд тойргоороо ажиллаад, ер нь гишүүдээс тавьсан саналууд ч гэсэн байж байгаа.

Энэ асуудалтай холбоотойгоор бид нар уг нь намрын чуулган завсарлахын өмнө Байнгын хороогоороо яамны мэдээллийг сонссон. Энэ чиглэлээр мэдээлэл өгсөн байгаа. Хөрөнгө оруулалтын чиглэлээр, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн чиглэлээр Байнгын хороо дээр Боловсрол, шинжлэх ухааны яам өөрөө энэ тайлангаа тавьсан. Тэр үед манай зарим гишүүд байгаагүй учраас энэ мэдээллүүдийг аваагүй байж магадгүй. Гэхдээ энэ цалинтай холбоотой асуудлуудаар сая Ундрам гишүүний асуусан асуултад яамны сайд энд байгаа юм чинь энэ чиглэлийн хариулт өгвөл яасан юм бэ гэж. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

**Л.Энх-Амгалан:** Энэ ТҮ-ийн цалингийн асуудал бол ганцхан манай боловсролын салбарын асуудал биш Ундрам гишүүн ээ. Үндсэндээ ТҮ-ийн саяын бид нарын цалингийн нэмэгдэл, босоо тогтолцоотой ТҮ-ийн ажилтнууд, хэвтээ болон орон нутагт байгаа ТҮ-ийн ажилтнуудын цалингийн нэмэгдэл дээр жоохон зөрүү гарсан. Энэ бол зөвхөн боловсрол дээр байгаа асуудал биш. Ерөөсөө бүх салбарт байгаа асуудал. Тийм учраас энийг Засгийн газар дээр ерөнхийдөө Ерөнхий сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад үүрэг өгөөд ерөнхийдөө Монгол Улсад байгаа цалингийн тогтолцооны асуудлыг тухайн салбараас шалтгаалахгүйгээр нэг тогтолцоог бий болгох ёстой юм байна гэдэг зүйлийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, улмаар Улсын Их Хуралд танилцуулах үүрэг чиглэл өгсөн байгаа. Энэ хүрээнд ажлууд хийгдэх болов уу гэж бодож байна.

Гэхдээ Байнгын хорооны дарга аа нэгэнт сая бид нар Улсын Их Хурлын чуулган завсарлаад Улсын Их Хурлын гишүүд бүгд тойрогтоо ажиллаад ирсэн учраас энэ тойрог дээр хийгдсэн уулзалт, уулзалтын үед ард иргэдээс гарсан саналуудыг манай Байнгын хороонд хамаарагдаж байгаа сэдвүүдээр

холбогдох сайд нарыг байлгаж байгаад гишүүдээс асуулт асуугаад, хариулт аваад сонссон нь зөв байх гэж бодож байна.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдын энэ саналыг Байнгын хороогоор оруулаад ер нь манай гишүүд ийм саналтай байгаа байх. Бүгд тойрогтоо ажиллаад, ялангуяа манай гол цөм салбар болсон соёлын салбар, боловсролын салбарын асуудлууд бол нэлээн яригдсан байх, гишүүдэд тодорхой хэмжээний саналуудыг тавьсан байх. Тийм учраас дараа дараагийн Байнгын хороогоор бол энэ чиглэлээр дахин тойрогтоо яригдаж байгаа зүйлүүдээр, энэ асуудлуудаар дахиад Байнгын хороогоор санал оруулаад ингээд холбогдох яамнуудаас хариулт авъя гэж төлөвлөгөөндөө оруулъя.

Өнөөдрийн гол асуудал цаглавар батлах тухай байгаа. Тийм учраас цаглавар дээр санал хэлэх гишүүн байна уу. Санал хэлэх гишүүн алга байна. Тэгэхээр Байнгын хороонд ганц асуудал бий.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолыг төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 7 гишүүн дэмжиж, 70 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

12.26 цаг

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал батлагдлаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Э.СУВД-ЭРДЭНЭ